



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Сэргэлэн сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/47/СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2021 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга	
	бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул	
	Утас: 7058-4203	Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:	И.Сэмжидмаа
	Утас: 7058-4207	Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a>
	Аудитор:	Э.Нандинчимэг
	Утас: 7000-3775	Цахим хаяг: <a href="mailto:khaanconsultingaudit@gmail.com">khaanconsultingaudit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд



## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Аудитын илрүүлэлт .....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	12
3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	14



## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 305

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН  
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Сэргэлэн сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Сэргэлэн сумын цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020292



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>31,146,838.70</b>	<b>29,452,094.70</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	31,146,838.70	29,452,094.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	28,938,279.70	27,492,534.70
35410	Бичиг хэргийн материал	587,300.00	349,500.00
35420	Аж ахуйн материал	27,722,979.70	27,143,034.70
35440	Түлц, шатах тослох материал	628,000.00	-
35600	Мал амьтад	2,208,559.00	1,959,560.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>174,560,572.05</b>	<b>183,065,178.52</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	174,560,572.05	183,065,178.52
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	146,560,572.09	153,065,178.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	106,527,077.58	106,527,077.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,009,135.04)	(10,189,070.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,094,900.00	36,576,235.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,493,801.69)	(8,568,925.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,628,751.58	24,755,281.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,242,020.38)	(7,704,980.66)
39209	Зам, гүүрийн байгууламж	18,181,000.00	18,181,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(5,126,199.96)	(6,511,439.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,200,000.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,200,000.00)	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	27,999,999.96	30,000,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,000,000.04)	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>205,707,410.75</b>	<b>212,517,273.22</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>205,707,410.75</b>	<b>212,517,273.22</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	205,707,410.75	212,517,273.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	114,226,086.00	114,226,086.00
51101	Өмч: - төрийн	114,226,086.00	114,226,086.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	29,581,924.06	36,391,786.53
51210	Өмнөх үеийн үр дүн	29,581,924.06	29,581,924.06
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,809,862.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,899,400.69	61,899,400.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>205,707,410.75</b>	<b>212,517,273.22</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (0)	259,131,000.00	226,373,565.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	259,031,000.00	226,285,565.00
120	Нийтлэг татварын бус орлого	84,300,000.00	17,852,165.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	84,300,000.00	17,852,165.00
122	Тусламжийн орлого	16,500,000.00	16,378,600.00
122005	Орон нутгийн санхүүжилт	16,500,000.00	16,378,600.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	158,231,000.00	192,054,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	158,231,000.00	192,054,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	100,000.00	88,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.00	88,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.00	88,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	180,737,555.05	221,398,702.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180,737,555.05	221,398,702.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,649,348.87	218,415,411.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,437,689.52	149,541,225.00
210101	Үндсэн цалин	91,645,103.00	113,470,468.00
210102	Нэмэгдэл	4,963,924.00	25,393,029.00
210104	Урамшуулал	7,828,662.52	10,677,728.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,386,937.52	19,209,353.00
210201	Тэтгэврийн даатгал	20,149,673.33	13,229,153.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,133,534.20	1,494,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	901,787.96	1,196,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	225,969.24	298,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,975,972.79	2,990,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,647,206.78	16,200,086.47
210301	Гэрэл, цахилгаан	1,100,000.00	1,349,565.47
210302	Түлш, халаалт	10,347,206.78	11,827,121.00
210303	Цэвэр, бохир ус	2,200,000.00	3,023,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,917,260.00	6,082,544.00
210401	Бичиг хэрэг	429,800.00	392,200.00
210402	Тээвэр, шатахуун	415,960.00	444,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	515,500.00
210404	Ном, хэвлэл	-	371,999.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	576,500.00	4,358,545.00
2105	Нормативт зардал	27,145,900.00	14,418,644.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,000.00	399,944.00
210502	Хоол, хүнс	27,075,900.00	14,018,700.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,513,200.00	733,000.00
210604	Урсгал засвар	2,513,200.00	733,000.00
2107	Томилголт, зочны зардал	280,000.00	-
210702	Дотоод албан томилголт	280,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	268,000.00	808,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,000.00	388,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,053,155.05	11,422,558.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	240,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	6,053,155.05	11,182,558.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,206.18	2,983,290.93
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,206.18	2,983,290.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,206.18	2,983,290.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	78,393,444.95	4,974,862.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	(1,835,000.04)
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	(1,835,000.04)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	1,835,000.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	78,393,444.95	6,809,862.47



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>174,831,000.00</b>	<b>208,521,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>174,731,000.00</b>	<b>208,433,400.00</b>
122	Тусламжийн орлого	16,500,000.00	17,962,200.00
122005	Орон нутгийн санхүүжилт	16,500,000.00	17,962,200.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	158,231,000.00	190,471,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	158,231,000.00	190,471,200.00
<b>13</b>	<b>ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>100,000.00</b>	<b>88,000.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.00	88,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.00	88,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>174,831,000.00</b>	<b>208,521,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>174,831,000.00</b>	<b>208,521,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>174,742,793.82</b>	<b>205,538,109.07</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,320,399.52	150,062,878.00
210101	Үндсэн цалин	95,363,800.00	113,992,122.00
210102	Нэмэгдэл	9,055,400.00	25,393,028.00
210104	Урамшуулал	8,901,199.52	10,677,728.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,533,027.52	18,687,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,000,527.52	12,707,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,133,000.00	1,494,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	906,600.00	1,196,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	226,400.00	298,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,266,500.00	2,990,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,985,206.78	15,548,686.47
210301	Гэрэл, цахилгаан	1,100,000.00	1,349,565.47
210302	Түлш, халаалт	10,485,206.78	11,199,121.00
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,333,260.00	3,475,200.00
210401	Бичиг хэрэг	429,800.00	417,800.00
210402	Тээвэр, шатахуун	415,960.00	444,300.00
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	515,500.00
210404	Ном, хэвлэл	123,000.00	123,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	869,500.00	1,974,600.00
2105	Нормативт зардал	26,509,700.00	14,778,644.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	399,944.00
210502	Хоол, хүнс	26,409,700.00	14,018,700.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,513,200.00	1,677,000.00
210604	Урсгал засвар	2,513,200.00	1,677,000.00
2107	Томилолт, зочны зардал	280,000.00	-
210702	Дотоод албан томилолт	280,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	268,000.00	808,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,000.00	478,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	330,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>88,206.18</b>	<b>2,983,290.93</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,206.18	2,983,290.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,206.18	2,983,290.93
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	114,226,086.00	61,899,400.69	29,581,924.06	0.00	205,707,410.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>114,226,086.00</b>	<b>61,899,400.69</b>	<b>29,581,924.06</b>	<b>0.00</b>	<b>205,707,410.75</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>114,226,086.00</b>	<b>61,899,400.69</b>	<b>29,581,924.06</b>	<b>0.00</b>	<b>205,707,410.75</b>
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>114,226,086.00</b>	<b>61,899,400.69</b>	<b>29,581,924.06</b>	<b>0.00</b>	<b>205,707,410.75</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>114,226,086.00</b>	<b>61,899,400.69</b>	<b>29,581,924.06</b>	<b>0.00</b>	<b>205,707,410.75</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,809,862.47	0.00	6,809,862.47
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>114,226,086.00</b>	<b>61,899,400.69</b>	<b>36,391,786.53</b>	<b>0.00</b>	<b>212,517,273.22</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	174,731,000.00	174,642,793.82	208,433,400.00	205,450,109.07
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	174,731,000.00	174,642,793.82	208,433,400.00	205,450,109.07
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	174,731,000.00	174,642,793.82	208,433,400.00	205,450,109.07
<b>2101</b>	<b>Цалин хөдс болон нэмэгдэл урамшил</b>	113,320,400.00	113,320,399.52	150,063,100.00	150,062,878.00
210101	Үндсэн цалин	95,363,800.00	95,363,800.00	113,992,200.00	113,992,122.00
210102	Нэмэгдэл	9,055,400.00	9,055,400.00	25,393,100.00	25,393,028.00
210104	Урамшуулал	8,901,200.00	8,901,199.52	10,677,800.00	10,677,728.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,619,500.00	15,533,027.52	18,687,700.00	18,687,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,087,000.00	11,000,527.52	12,802,600.00	12,707,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,133,000.00	1,133,000.00	1,471,300.00	1,494,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	906,600.00	906,600.00	1,177,000.00	1,196,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	226,400.00	226,400.00	294,300.00	298,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,266,500.00	2,266,500.00	2,942,500.00	2,990,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,985,800.00	13,985,206.78	16,285,200.00	15,548,686.47
210301	Гэрэл, цахилгаан	1,100,000.00	1,100,000.00	1,350,000.00	1,349,565.47
210302	Тууш, халаалт	10,486,800.00	10,485,206.78	11,935,200.00	11,199,121.00
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,400,000.00	3,000,000.00	3,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,233,400.00	2,233,260.00	3,387,200.00	3,387,200.00
210401	Бичиг хэрэг	329,800.00	329,800.00	329,800.00	329,800.00
210402	Гэвээр, шатахуун	416,000.00	415,960.00	444,300.00	444,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	495,000.00	515,500.00	515,500.00
210404	Ном, хэвлэл	123,000.00	123,000.00	123,000.00	123,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	869,600.00	869,500.00	1,974,600.00	1,974,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,509,700.00	26,509,700.00	17,020,200.00	14,778,644.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	100,000.00	478,000.00	399,944.00
210502	Хоол, хүнс	26,409,700.00	26,409,700.00	16,212,200.00	14,018,700.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	330,000.00	360,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,513,200.00	2,513,200.00	1,677,000.00	1,677,000.00
210604	Урсгал засвар	2,513,200.00	2,513,200.00	1,677,000.00	1,677,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	280,000.00	280,000.00	-	-
210702	Дотоод албан томиллолт	280,000.00	280,000.00	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	268,000.00	268,000.00	813,000.00	808,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,000.00	88,000.00	483,000.00	478,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00	330,000.00	330,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	500,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	500,000.00	500,000.00
	<b>ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	174,731,000.00	174,642,793.82	208,433,400.00	208,433,400.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	174,731,000.00	174,642,793.82	208,433,400.00	208,433,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих				
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	174,731,000.00	174,642,793.82	208,433,400.00	208,433,400.00



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>88,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>88,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	88,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	88,000.00
210401	Бичиг хэрэг	88,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	88,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	88,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,000.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сэргэлэн сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Энхцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Сэргэлэн сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Сэргэлэн сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль бусад холбогдох тушаалын шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон цэцэрлэгийн насны хүүхдийг асрах, хамгаалах цогц үйл ажиллагаагаар бие бялдар, оюун ухааныг нийгэмшүүлэн хөгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо болгон ажиллаж байна. 150 хүүхдийн шинэ цэцэрлэгийн шав тавьсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Сэргэлэн сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Сэргэлэн сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож,

эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 219,563.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 4,391.2 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сэргэлэн сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,809.8 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	31,146.8	29,452.1	-1,694.7
Үндсэн хөрөнгө	204,831.7	216,239.6	11,407.9
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-30,271.2	-33,174.4	-2,903.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>205,707.4</b>	<b>212,517.2</b>	<b>6,809.8</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	114,226.1	114,226.1	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>205,707.4</b>	<b>212,517.2</b>	<b>6,809.8</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 29,452.1 мянган төгрөг болж 1,694.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 216,239.6 мянган төгрөг болж 11,407.9 мянган төгрөгөөр өссөн нь 17,852.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авч, 6,444.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Сэргэлэн сумын цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 32,757.4 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 40,661.1 мянган төгрөгөөр буюу 22.0 хувиар өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 208,433.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 208,433.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 208,433.4 мянган төгрөгөөр баталсан байна.



### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 208,433.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 208,433.4 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 208,433.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 88.0 мянган төгрөг нийт 208,521.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 205,538.1 мянган төгрөгийг зарцуулж 2,983.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 205,538.1 мянган төгрөг буюу 98,6 хувьтай байна. Үүнээс цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 168,750.6 мянган төгрөг буюу 82.1 хувьтай байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт үйл ажиллагаанаас 88.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Бичиг хэргийн зардалд 88.0 мянган төгрөг зарцуулсан.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 143 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа хоцорч 3 мэдээлэл оруулсан. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн 82,668.8 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч оруулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

2019 оны Санхүүгийн тайлангаар өгсөн аудитын зөвлөмжийг биелүүлэн ажиллаж 1 төлбөрийн актыг төлж биелэлтийг хугацаандаа өгсөн байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,297.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,297.2 мянган төгрөгийн зөрчилд 198.3 мянган төгрөгийн төлбөрийн акт 1 тогтоож, 4,098.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 4,297.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,297.2 мянган төгрөгийн зөрчилд 198.3 мянган төгрөгийн төлбөрийн акт 1 тогтоож, 4,098.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 198.3 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.



Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

- Худалдан авалтын үнийн гэрээний үнэ болон тендерийн үнийн саналтай харьцуулахад 583.1 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

- Тайлант хугацаанд гарсан зардлаас 3,515.8 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Хоол хүнсний худалдан авалтыг гэрээний үнийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж үнэлэлт өгч байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорнод аймгийн Сэргэлэнн сумын цэцэрлэг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021.02.25			ДОА-2021/47/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Сэргэлэн сумын цэцэрлэг		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нийт 140 мэдээллийг хугацаандаа байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд: 1. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) 2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) 5 сард мөнгөн дүн 82,668.8 мянган төгрөг 3. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр) 3 сард	0.0	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Энхцэцэг Б.Оюунхуар
2	Хүнсний худалдан авалтаас түүвэрлэлт хийж Алсын хайрхан ХХК-ний гэрээний хавсралт дахь үнийн жагсаалтыг худалдан авалтын үнэтэй харьцуулахад 583.1 мянган төгрөгийн илүү үнээр худалдан авсан байна	583.1	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Энхцэцэг Б.Оюунхуар
3	Цахим төлбөрийн баримтад 3,515.8 мянган төгрөгийн и-баримтыг илгээгдээгүй байна.	3,515.8	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Энхцэцэг Б.Оюунхуар
4	Батлагдсан төсөв 444.3 мянган төгрөг ба зарцуулалт батлагдсан төсвөөс хэтрээгүй ч жишиг нормоор тооцоолоход 198.3 мянган төгрөгийн илүү зарцуулалттай байна.	198.3	Төлбөрийн акт тогтоох	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Энхцэцэг Б.Оюунхуар
<b>ДҮН</b>		<b>4,297.2</b>			